



# АМЕП 2 МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

АМЕП-ийн Мэдээ | Дугаар 8 | Огноо: July 27, 2021

**Adam Smith  
International**

АСИ бол улс орнуудын эдийн засгийг хүчирхэгжүүлж, нийгэмд тогтвортой байдал бий болгон, засгийн газруудыг илүү үр дүнтэй ажиллахад нь туслах замаар иргэдийн амьдралд өөрчлөлт авчрах зорилготой, 25 жилийн түүхтэй, дэлхийд тэргүүлэх зөвлөх компани юм. Засгийн газруудад өндөр чанартай зөвлөх үйлчилгээ үзүүлснээр тухайн улсын ард иргэдийн амьдрал ахуйг дээшлүүлж, урт хугацаанд тогтвортой үргэлжлэх өөрчлөлт шинэчлэлт хийсээр ирлээ. Өдгөө дэлхийн 30 гаруй оронд үйл ажиллагаагаа явуулж буй АСИ 250 үндсэн ажилтан, салбартаа мэргэшсэн 2,000 гаруй зөвлөхтэй мэргэжилтэнтэй. АСИ Монгол Улсын Засгийн газартай 2011 оноос эхлэн хамtran ажиллаж байгаа бөгөөд салбар оффисоо 2014 онд

Улаанбаатарт нээжээ. Өнгөрсөн хугацаанд МУ-ын эрдэс баялаг, дэд бүтцийн салбар, мөн засаглалын шинэчлэлийн сэдвээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн.

АСИ-ийн Монгол дахь Захирал Баярсайханы Мандхай Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП 2)-ын Хөтөлбөрийн Захирлын албан тушаалыг давхар хашихын зэрэгцээ бусад хөтөлбөрийг удирдаж байна. Б.Мандхай нь Адам Смит Интернэшнл (АСИ) олон улсын зөвлөх үйлчилгээний байгууллагад 2016 оноос хойш тасралтгүй ажиллахдаа Зүүн Африк, Зүүн Өмнөд Азийн орнууд, Их Британийн дэд бүтэц, эрчим хүч, олборлох салбарын төслүүдийг хариуцан ажиллажээ.

## ЭНЭ ДУГААРТ

АМЕП 2 хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэгч нь Адам Смит Интернэшнл (АСИ) олон улсын байгууллага бөгөөд тус байгууллагын корпорацийн хамтрагч нь Sustainability East Asia (CEA) юм. Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах чиглэлд АМЕП 2 хөтөлбөр 2020-2021 онд хэд хэдэн ажил хийж гүйцэтгэж байна. Эдгээрийн нэг нь АСИ, СЕА-гийн Байгаль орчны аудиторуудын холбоо (БОАХ)-той хамтран хэрэгжүүлж буй EASY2020 төсөл билээ. Тус төслийн үр дүнд байгаль орчны аудитын чанарыг хэрхэн сайжруулж буй талаар энэ мэдээллийн хуудсаас дэлгэрэнгүй мэдээлэл аваарай.



**SUSTAINABILITY  
EAST ASIA LLC**

Sustainability East Asia (CEA) олон улсын байгууллага Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулаад 15 жил болжээ. СЕА нь Монгол Улсад бүртгэлтэй бөгөөд тус салбарын дийлэнхийг Монголчууд эзэмшдэг, Улаанбаатарт оффистой. Олон улсын зээлдэгч, санхүүгийн институтиудын итгэлт түвш СЕА нь Европын Сэргээн босголт, хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Азийн хөгжлийн банк, хөгжих буй орнуудад зориулсан Белгийн хөрөнгө оруулалтын компани, Нидерландын Энтерпренерийн хөгжлийн банк зэрэг байгууллагаас санхүүжүүлдэг төслүүдэд байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, мониторинг хийдэг. СЕА нь ВС Аткинс Интернэшнл, Оюу Толгой, Эрдэнэ Монгол, Хаан банк, ОУСК-иас санхүүжүүлсэн Усны менежментийн хөтөлбөр, АМЕП зэрэг дотоод болон олон улсын хэмжээний компани, төсөлд зориулан, олон улсын стандартад нийцсэн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, нийгэм, байгаль орчны үйлчилгээ үзүүлдэг.

## 2020-2021 ОНЫ ИЛТГЭЛ ТАЙЛАНГУУД

Та бүхэн АМЕП 2 хөтөлбөрийн үндэсний болон олон улсын мэргэжилтнүүдийн 2020-2021 онд бэлтгэсэн илтгэл, судалгаануудыг

манай цахим хуудсаас ([amer.mn](http://amer.mn)) үзээрэй. Тайлан илтгэлүүдийн шууд холбоос: <https://www.amer.mn/news-detail/31>

# Байгаль орчны аудитын холбоотой хамтран ажиллалаа

Энэ онд АМЕП 2 хөтөлбөрөөс хэрэгжүүлсэн зургаан төслийн нэг нь БОАЖЯ-ны дэмжлэгтэйгээр Байгаль орчны аудитын холбоо (БОАХ)-той хамтран хэрэгжүүлсэн “Байгаль орчны аудитын институцийн чадавхийг бэхжүүлэх, чанарын баталгаажуулалтын тогтолцоог нэвтрүүлэх EASY2020” хөтөлбөр байлаа. Байгаль орчны аудитын мэргэжлийн стандартыг тогтоож өгч байгаа энэхүү чанарын баталгаажуулалтын тогтолцоо нь уул уурхайн салбарт түгээмэл хэрэглэгддэг олон улсын стандартыг



Монгол улсад нэвтрүүлэхэд чухал ач холбогдолтой. EASY2020 төслийн үр дүнд БОАХ нь олон улсын ISO 17 024 гэрчилгээ хүлээн авсан Монголын анхны мэргэжлийн холбоо боллоо.

БОАХ-ны Удирдах зөвлөлийн гишүүд байгаль орчны аудиторуудыг тасралтгүй суралцах боломжоор хангаж, санал хүсэлтүүдийг нээлттэй хүлээн авах удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх сургалтад хамрагдсан. Шинэчилж сайжруулсан аудитын баталгаажуулалтын тогтолцоо нь үнэ цэн түгээх, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байх зарчимд суурилжээ. АМЕП 2 хөтөлбөрийн мэргэжилтнүүдийн тусламжтайгаар БОАХ 20 орчим бодлого, дүрэм журмын бичиг баримтаяа шинэчилж, гишүүддээ дээд зэргийн үйлчилгээ үзүүлдэг үлгэр жишээ мэргэжлийн институци боллоо.

Олон улсад байгаль орчны аудитын сургалт явуулдаг Exemplar Global байгууллагын Ахлах зөвлөх Крис Кутино харьцуулсан судалгаан дээр үндэслэн, олон улсын стандартад нийцсэн, 12 сэдэв бүхий байгаль орчны аудиторын сургалтын модул боловсруулжээ. Тэрээр, “Аудиторууд ур чадвараа нэмэгдүүлж, байгаль орчны аудитын талаар зөв хандлагатай болсноор цогц чадамжийг бүрдүүлнэ. Үр дүнд чиглэсэн энэхүү сургалтын модул нь онолыг практикт хэрэглэж сурх, системийн мэдрэгийг байгаль орчны аудиторуудад олгох зорилготой” гэж ярьсан юм.

БОАХ-ны гишүүд, удирдлагууд шинэ дүрэм журамтай танилцах, чадавхи нэмэгдүүлэх 16 цуврал сургалтад хамрагдаж, улмаар БОАЖЯ, УУХҮЯ, байгаль орчны аудитын мэргэжлийн холбоод, уурхайн компанийн төлөөллүүдийг оролцуулсан сургалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа. Сургалтанд оролцсон аудиторуудын нэг болох Монгол Улсын Хими, хими технологийн хүрээлэнгийн Хүнсний лабораторийн эрхлэгч, Эрдэм шинжилгээний ажилтан, Доктор Б. Баярмаа, “АМЕП, БОАХ-ны сургалтад сууснаар байгаль орчны аудитын ажлаа илүү үнэ цэнэтэй гэдгийг ойлгож авлаа. Бид ажлаа илүү өргөн хүрээнд харж, мөн үйлчлүүлэгч байгууллагадаа үнэ цэнэ нэмэх, нэг бус олон талын баримт нотолгоо гаргаж өгөх ёстой. Төслөөс байгаль орчин, хүнд учрах хор хохирлыг аль болох бага байлгах нь зөвхөн байгаль орчны аудиторын биш компани, хүмүүс, засгийн ч ажил шүү дээ” гэсэн юм.

Төслийн үр дүнд уул уурхайн компаниуд байгаль орчны өндөр чанартай аудитын үйлчилгээ авах боломжтой болсныг дуулгахад таатай байна. Төслийн бас нэг үр дүн бол БОАХ-ны хийсэн байгаль орчны аудитын тогтолцооны шинэчлэлтийг уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдыг эгнээндээ нэгтгэсэн Монголын Банкуудын Холбоо талархан хүлээн авч, цаашид зээлийн үнэлгээндээ “байгаль орчны тайланг гэрчилгээт аудитороор гаргуулсан байх” гэсэн шалгуурыг зээл олгох нөхцөлдөө нэмэх бодолтой буйгаа мэдэгдсэн явдал юм.

Тус төсөл уул уурхайн компаниудын байгаль орчин, үйл ажиллагаандаа хүлээх хариуцлагыг сайжруулах замаар тухайн уурхайн төсөл дэх хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж байна.